



ХҮЛЭГТ ХҮННУ АУДИТ ХХК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"МОСТ ФИНТЕК" ХК

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

“МОСТ ФИНТЕК” ХК

АГУУЛГА

Удирдлагын хариуцлагын мэдэгдэл	3
Байгууллагын талаарх мэдээлэл	4
Хараат бус аудиторын тайлан	5

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүүгийн байдлын тайлан	7
Орлогын дэлгэрэнгүй тайлан	8
Өмчийн өөрчлөлтийн тайлан	9
Мөнгөн гүйлгээний тайлан	10

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

1. Компанийн талаарх мэдээлэл.....	11
2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй.....	11
3. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, төсөөллүүд.....	19
4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба толилуулгад орсон өөрчлөлтүүд.....	19
5. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	20
6. Дансны авлага болон бусад авлага	20
7. Бараа материал	21
8. Урьдчилж төлсөн зардал, тооцоо.....	21
9. Бусад эргэлтийн хөрөнгө.....	22
10. Үндсэн хөрөнгө.....	22
11. Биет бус хөрөнгө.....	22
12. Урт хугацаат хөрөнгө оруулалт.....	23
13. Бусад эргэлтийн бус хөрөнгө	23
14. Дансны ба бусад өглөг.....	24
15. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	24
16. Хойшлогдсон татварын өр.....	24
17. Хувьцаат капитал.....	25
18. Нэгж хувьцаанд ногдох ашиг.....	25
19. Халаасны хувьцаа.....	25
20. Нэмж төлөгдсөн капитал	25
21. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл.....	26
22. Эздийн өмчийн бусад хэсэг.....	26
23. Борлуулалтын орлого (цэвэр).....	26
24. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг.....	26
25. Хүүгийн болон бусад орлого	27
26. Бусад олз ба (гарз).....	27
27. Борлуулалт, маркетингийн зардал.....	27
28. Ерөнхий ба удирдлагын зардал, бусад зардал.....	27
29. Бусад зардал.....	28
30. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл.....	28
31. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдэлийн удирдлага.....	30
32. Капиталын эрсдлийн удирдлага	30
33. Гэрээний үүрэг.....	31
34. Тайлангийн дараах үйл явдал	31
35. Орчуулга	31
36. Хураангуй товчлол.....	31

МОСТ ФИНТЕК ХК

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

МОСТ Финтек ХК-ийн (цаашид "Компани" гэх) Гүйцэтгэх захирал Сүхдорж овогтой Оргил, Ерөнхий нягтлан бодогч Норжий овогтой Урнаа, бид энэхүү тайлангийн 1-ээс .. дугаар хуудсанд толилуулсан тайлангуудыг холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



СҮХДОРЖ ОРГИЛ
Гүйцэтгэх захирал

A handwritten signature in black ink, appearing to read "Н. Урнаа".

НОРЖИЙ УРНАА
Ерөнхий нягтлан бодогч

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2026 оны 03 дугаар сарын 09

"МОСТ ФИНТЕК" ХК

Байгууллагын талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулах шийдвэр

"МОСТ ФИНТЕК" ХК нь 2008 оны 04 сарын 01-ний өдрийн үүсгэн байгуулагчдын №01 тоот тушаалын дагуу Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан. 2023 оны 10 сарын 25-ны өдөр санхүүгийн зохицуулах хорооны 508 тоот тушаалын дагуу хувьцаагаа олон нийтэд санал болгохыг, үнэт цаасыг бүртгэхийг, нээлттэй Хувьцаат Компани болж өөрчлөхийг тус тус зөвшөөрсөн.

Гэрчилгээ ба тусгай зөвшөөрөл

"МОСТ ФИНТЕК" ХК нь 2008 оны 04 сарын 23-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж 5220351 тоот регистрийн дугаар бүхий, Улсын бүртгэлийн 9011146138 тоот гэрчилгээг авсан. 2024 оны 5 сарын 2-ны өдөр Улсын бүртгэлийн 9007001021 тоот гэрчилгээний дугаараар дахин авсан.

Хувь нийлүүлэгчид

СҮХДОРЖ	28.6%
ОРГИЛ	15.3%
АРД КРЕДИТ ББСБ ХК	12.3%
АРДЫН ТЭТГЭВРИЙН ДАНС ХХК	10.2%
ГРЭЙПСИТИ МОНГОЛ ХХК	6.7%
АРД СЕКЮРИТИЗ ҮЦК ХХК	5.8%
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК	3.3%
ЖИ ЭС БИ КАПИТАЛ ББСБ ХХК	2.3%
ЭЙЧ ВИ ЭЛ ЭЛ ХХК	2.2%
МОСТ ФИНТЕК ХК	1.4%
АРД ПРОПЕРТИЗ ХХК	1.3%
БУСАД	10.5%

Гүйцэтгэх удирдлага

С.Оргил Гүйцэтгэх захирал

Хаяг

"МОСТ Финтек" ХК
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Сүхбаатарын талбай-2,
Сэнтрал тауэр 13 давхар, 1313 тоот

Аудитор

"Хүлэгтхүннү Аудит" ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Энхтайвны өргөн чөлөө, 13/3, Авзага трейд, 8 давхар 803
тоот
Утас/Факс: +(976)-7014 0505

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

МОСТ Финтек ХК-ийн хувьцаа эзэмшигчид

Дүгнэлт

Бид МОСТ Финтек ХК (цаашид "компани" гэх)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид, компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын лон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "МНБЕЗ-н дүрэм" гэх)-ийн дагуу компаниас хараат бус ба МНБЕЗ-н дүрмийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Санхүүгийн тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн, шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга

материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Үүнээс гадна:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил, дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Гарын үзэг зурсан:

Ид. Гүррагчаа
Гүйцэтгэх захирал
Хүлээтхүүн Аудит ХХК

2028 оны 03 дугаар сарын 09-ны өдөр
Монгол Улс, Улаанбаатар хот

► МОСТ ФИНТЕК ХК-ийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Төгрөгөөр	Тодруулгын дугаар	2025 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5	682,285,678	774,338,031
Дансны авлага болон бусад авлага	6	4,381,900,067	3,901,219,552
Бараа материал	7	1,329,335	878,458
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8	550,967,310	430,885,755
Бусад эргэлтийн хөрөнгө	9	1,900,000,000	1,900,000,000
		7,516,482,390	7,007,321,795
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	10	603,049,717	755,258,212
Биет бус хөрөнгө	11	5,008,295,483	4,934,918,147
Урт хугацаат хөрөнгө оруулалт	12	2,468,094,852	1,828,094,852
Бусад эргэлтийн бус хөрөнгө	13	3,607,458,782	2,746,139,043
		11,686,898,834	10,263,410,254
Нийт хөрөнгө		19,203,381,225	17,270,732,049
Өр төлбөр ба эздийн өмч			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны болон бусад өглөг	14	396,237,997	454,106,543
Татвар, НДШ-ийн өглөг	15	52,055,190	85,680,129
		448,293,187	539,786,673
Урт хугацаат өр төлбөр			
Хойшлогдсон татварын өр	16	111,382,368	17,157,119
		111,382,368	17,157,119
Өр төлбөрийн нийт дүн		559,675,555	556,943,792
Эздийн өмч			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	17	4,859,697,000	4,859,697,000
Халаасны хувьцаа	18	(272,160,007)	(272,160,007)
Нэмж төлөгдсөн капитал	20	6,795,689,845	6,795,689,845
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	21	4,186,049,897	3,299,884,178
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	22	-	154,414,071
Хуримтлагдсан ашиг алдагдал		3,074,428,936	1,876,263,171
Эздийн өмчийн дүн		18,643,705,670	16,713,788,257
Нийт өр төлбөр ба эздийн өмч		19,203,381,225	17,270,732,049

11-31 дугаар хуудсанд хэвсгэрсэн нэмэлт тодруулагууд нь эдгээр санхүүгийн тайланыгн сэлшгүй хэсэг болно.

» МОСТ ФИНТЕК ХК-ийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Төгрөгөөр	Тодруулгын дугаар	2025 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	23	2,814,983,269	2,386,651,006
Борлуулсан барааны өртөг	24	101,150,985	85,755,788
Нийт ашиг (алдагдал)		2,713,832,284	2,300,895,220
Хүүний орлого	25	693,732,494	696,117,235
Борлуулалт, маркетингийн зардал	27	639,326,298	582,061,592
Ерөнхий ба удирдлагын зардал, бусад зардал	28,29	1,579,408,225	1,416,914,889
Бусад олз (гарз)	26	3,046,881	1,920,114
Татварын өмнөх ашиг (алдагдал)		1,191,877,235	1,019,956,288
Орлогын татварын зардал		115,315,913	97,132,105
Татварын дараах ашиг (алдагдал)		1,076,561,322	922,824,183
Тайланг үеийн цэвэр ашиг алдагдал		1,076,561,322	922,824,183
Бусад дэлгэрэнгүй орлого		1,002,441,311	(7,974,331)
Орлогын нийт дүн		2,079,002,634	914,849,852

11-31 дугаар хуудсанд хавсаргасан нэмэлт тодруулагууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

» МОСТ ФИНТЕК ХК-ийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр	Өмч	Халааны хувьцаа	Нэмэгдсэн капитал	Хөрөнгийн дахин уналтгажгүй нэмэгдэл	Өзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан шилэг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31	4,859,697,000	(272,160,007)	6,795,689,845	3,307,868,509	-	881,413,319	16,582,498,566
Залруулсан үндэсгэл	4,859,697,000	(272,160,007)	6,795,689,845	3,307,868,509	-	881,413,319	16,582,498,566
Тайлалт үеийн ашиг (алдагдал)	-	-	-	-	-	922,824,180	922,824,180
Бусад даатгарангүй орлого	-	-	-	(7,974,331)	154,414,071	(7,974,331)	138,465,409
2024 оны 12-р сарын 31	4,859,697,000	(272,160,007)	6,795,689,845	3,299,894,178	154,414,071	1,876,263,171	16,713,788,257
Нягтлан бодох бүртгэлийн Бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	-
Залруулсан үндэсгэл	4,859,697,000	(272,160,007)	6,795,689,845	3,299,894,178	154,414,071	1,876,263,171	16,713,788,257
Тайлалт үеийн ашиг (алдагдал)	-	-	-	-	-	1,076,561,322	1,076,561,322
Бусад даатгарангүй орлого	-	-	-	1,002,441,311	(154,414,071)	116,276,592	964,303,833
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	5,328,850	5,328,850
Дахин уналтгажгүй нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	(116,276,592)	-	-	(116,276,592)
2025 оны 12-р сарын 31	4,859,697,000	(272,160,007)	6,795,689,845	4,185,049,897	-	3,074,428,936	18,543,706,670

11-31 дугаар хуудсанд хавсаргасан нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн твйлангийн салшгүй хэсэг болно.

►МОСТ ФИНТЕК ХК-ийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Төгрөгөөр	2025 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	2,704,882,450	2,749,965,531
Бараа борлуулсан, үйчилгээ үзүүлсний орлого	2,626,944,520	2,461,310,719
Бусад мөнгөн орлого	77,937,930	288,654,812
Мөнгөн зарлагын дүн (-)	2,654,166,959	2,630,110,478
Ажиллагчдад олгосон мөнгө	851,024,693	809,255,143
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	239,384,192	215,233,450
Ашиглалтын зардал төлсөн	6,236,353	635,571
Түлш шатахуун тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	216,889	867,240
Татаарын байгууллагад төлсөн	384,893,419	254,982,876
Бусад мөнгөн зарлага	1,172,411,414	1,349,136,199
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	50,715,491	119,855,053
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	624,947,655	2,479,257,883
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	1,900,000,000
Хүлээн авсан хүүний орлого	624,947,655	579,257,883
Мөнгөн зарлагын дүн (-)	767,725,942	2,380,482,789
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	127,725,942	175,839,726
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	640,000,000	1,304,643,064
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	900,000,000
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(142,778,287)	98,775,094
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн зарлагын дүн (-)	-	272,160,007
Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	-	272,160,007
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(272,160,007)
Валютын ханшны зөрүү	10,443	(364)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(92,052,352)	(53,530,225)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	774,338,031	827,868,256
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	682,285,678	774,338,031

11-31 дугаар хуудсанд хавсаргасан нэмэлт тодруулауд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

1. Компанийн талаарх мэдээлэл

1.1 Танилцуулга, зохион байгуулалт

"МОСТ Финтек" Хувьцаат Компани (цаашид "компани" гэх) нь 2008 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр "МОСТ ПСП" нэртэйгээр Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан. Компани нь Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг, компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнд хариуцлага хүлээдэг компани юм.

Компанийн нэрийг 2018 оны 06-р сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралдаанаар МОСТ Финтек ХХК болгон өөрчлөн бүртгүүлсэн байна.

2023 оны 10 сарын 25-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны 508 тоот тушаалын дагуу хувьцаагаа олон нийтэд санал болгохыг, үнэт цаасыг бүртгэхийг, нээлттэй Хувьцаат Компани болж өөрчлөхийг тус тус зөвшөөрсөн.

Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал удирдан зохион байгуулдаг.

1.2 Үндсэн үйл ажиллагаа, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

Компани нь төлбөр тооцооны дэвшилтэт технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг. 2025 оны 01 сарын 24-ний өдөр Монголбанкнаас Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх тусгай зөвшөөрлийг 4 жилийн хугацаатай олгосон.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй

2.1 Мөрдсөн стандарт

Санхүүгийн тайлангаа Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэсэн.

2.2 Тайлан бэлтгэсэн суурь

Санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдсөн хэмжилтийн гол суурь нь түүхэн өртөг. Түүхэн өртөг нь хөрөнгийг худалдан авах үед төлсөн эсвэл солилцсон зүйлийн бодит үнэ цэнэ байна. Гэхдээ СТОУС-аар шаардсаны дагуу санхүүгийн элементүүдийн хэмжилтэнд түүхэн өртөг, тайлант үеийн өртөг, боломжит үнэ цэнэ, өнөөгийн үнэ цэнэ, бодит үнэ цэнэ зэрэг хэд хэдэн ялгаатай аргыг дангаар нь болон хослуулан ашигласан.

Компанийн санхүүгийн тайлангуудыг үйл ажиллагааны үндсэн мөнгөн тэмдэгт болох "Монгол төгрөг"-өөр илэрхийлсэн. Бүх санхүүгийн мэдээллийг өөрөөр заагаагүй бол "мянган төгрөг"-өөр илэрхийлсэн.

2.3 Санхүүгийн хэрэглүүр

Санхүүгийн хэрэгслүүд-хэмжилтийн үндсэн нэр томъёо: Санхүүгийн хэрэгслүүдийн ангиллаас хамааран тэдгээрийг дор тайлбарласны дагуу бодит үнэ цэнэ, анхны өртгөөр, эсвэл хорогдуулсан өртгөөр бүртгэлд тусгана.

Бодит үнэ цэнэ нь хэмжилтийн өдөр зах зээлд оролцогч талууд сайн дураараа хоорондоо хөрөнгө худалдах, эсвэл хөрөнгө солилцох, өр төлбөр барагдуулахад төлөх үнэ юм. Бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо нь идэвхитэй зах зээлийн жишиг үнэ юм. Идэвхитэй зах зээл гэдэг нь хөрөнгө ба өр төлбөртэй холбоотой үнийн талаарх хангалттай их хэмжээгээр гүйлгээнүүдийн талаарх мэдээллийг байнга авч болох гарзыг хэлнэ.

Санхүүгийн хэрэгслүүдийн үнэ нь хөрөнгийн зах зээл, эсвэл бусад байгууллагаас тогтмол нийтэд зарлагдах буюу бэлэн олдох боломжтой бөгөөд эдгээр үнээр зах зээл дээр бодит гүйлгээ тогтмол хийгддэг тохиолдолд санхүүгийн хэрэгслүүдийг идэвхитэй зах зээл дээр санал болгосон гэж үзнэ.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.3 Санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)

Зах зээлийн үнийн талаар гаднаас мэдээлэл олдохгүй байгаа зарим санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийг тогтооходоо дискаунтчилсан мөнгөн гүйлгээний үнэлгээний загвар, холбоогүй талуудын хооронд хамгийн сүүлд хийгдсэн хэлцлийн талаарх санхүүгийн мэдээлэл дээр үндэслэн, үнэлгээний загвар болон хөрөнгө оруулалтын объектын талаарх санхүүгийн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээг ашиглаж тооцно. Үнэлгээний аргачлалуудад зах зээлийн нээлттэй мэдээлэл ашиглах боломжгүй үед таамаглалыг ашигладаг.

Анхны өртөг гэдэг нь худалдан авалтын өдөр төлөгдсөн мөнгөн хөрөнгө буюу түүнтэй адилтгах хөрөнгийн дүн, эсвэл хөрөнгө худалдаж авахад зориулагдсан бусад нөөцийн бодит үнэ бөгөөд үүнд хэлцэл болон ажил гүйлгээний зардлууд орно.

Гүйлгээний зардлууд нь санхүүгийн хэрэгслийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардлууд гэдэг нь гүйлгээ хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх зардал болно. Гүйлгээний зардалд зуучлагч, борлуулагч зуучлагчийн үүрэг гүйцэтгэж буй ажилтнууд, зөвлөх, брокер, диллөрүүдэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулагч агентлаг, хөрөнгийн биржийн ногдуулсан хураамж төлбөр, мөн өмчлөлийн эрхийг шилжүүлэхэд ногдуулсан татвар хураамжууд хамаарна. Гүйлгээний зардалд өрийн хямдруулалт буюу урамшуулал, санхүүжилтийн зардал, дотоод удирдлагын буюу хадгалалтын зардлууд орохгүй.

Хорогдуулсан өртөг гэдэг нь санхүүгийн хэрэгслүүдийг анхлан хүлээн зөвшөөрсөн дүнгээс үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж өгсөн дүн, харин санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрсөн урамшууллын хойшлогдсон гүйлгээний зардал, мөн хөнгөлөлтийн дүнг үр ашигт хүүгийн аргаар тооцсон хямдруулалт орно. Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн хямдруулсан урамшуулал буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй ба тэдгээрийг санхүүгийн байдлын тайланд хамаарах хэсэгт бүртгэлийн үнээр тусгасан болно.

Үр ашигт хүүний арга гэдэг нь хүүний орлого эсвэл хүүний зардлыг хамаарах хугацааны туршид санхүүгийн хэрэгслийн дансны үнээс тооцогдох хүүний хувийг тогтмол байлгахгаар (үр ашигт хүүний хувь) хуваарилах арга юм. Үр ашигт хүүний хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого болон гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэгслүүдийн хүлээгдэж буй хугацаа эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид хямдруулж, санхүүгийн хэрэгслүүдийн бүртгэлийн цэвэр дүнг гаргаж авах хүүний хувь болно. Үр ашигт хүүний хувь нь хувьсах хүүтэй санхүүгийн хэрэгслүүдийн мөнгөн урсгалыг хүү өөрчлөгдөх дараагийн мөч хүртэл дискаунтчилах бөгөөд санхүүгийн хэрэгсэлд тусгагдсан хөвөх хүү дээр намэгдэх зээлийн хүүний зөрүүг илэрхийлсэн урамшуулал болон хөнгөлөлт мөн зах зээлийн ханшийн түвшинтэй уялдан өөрчлөхгүй бусад хувьсах хүчин зүйлсийн нөлөөг дискаунтчилахгүй. Эдгээр урамшуулал болон хөнгөлөлтийг хэрэгслүүдийн хүлээгдэж буй нийт хугацааны туршид хорогдуулна. Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд гэрээний талуудын хооронд төлөх эсвэл хүлээн авах бүх хураамжийг оруулах бөгөөд тэдгээр нь үр ашигт хүүний бүрэлдэхүүн хэсэг болно. Санхүүгийн хэрэглүүрүүдийг ангиллаас нь хамааруулан бодит үнэ цэнэ, эсвэл хорогдуулсан өртгөөр дор тайлбарласны дагуу бүртгэлд тусгадаг.

2.3.1 Санхүүгийн хөрөнгийн ангилал

Санхүүгийн хөрөнгийг "зээл ба авлага"-аар ангилсан. "Зээл ба авлага"-д компанийн ойрын ирээдүйд худалдах төлөвлөгөөгүй бөгөөд тогтмол, тодорхойлж болохуйц төлбөртэй, хөрөнгийн идэвхитэй зах зээлд бүртгэлгүй, үүсмэл бус (дериватив бус) бүх санхүүгийн хөрөнгийг хамруулдаг. "Зээл ба авлага"-д дансны ба бусад авлага, касс болон харилцах дансан дахь мөнгөн хөрөнгө, урьдчилгаа төлбөрүүд багтсан.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.3 Санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)

2.3.2 Санхүүгийн өр төлбөрийн ангилал

Санхүүгийн өр төлбөрийг "санхүүгийн бусад өр төлбөр"-өөр ангилсан. Санхүүгийн бусад өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

2.3.3 Санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрөх

Хууль тогтоомжоор эсвэл тухайн зах зээлийн дүрэм журмаар тогтоосон хугацаанд шилжүүлэхээр заасан санхүүгийн хөрөнгийн худалдан авалт ба борлуулалт (энгийн нөхцөлөөр гүйцэтгэх худалдан авалт ба борлуулалт)-ыг гүйлгээ хийсэн өдрөөр, өөрөөр хэлбэл компанийн санхүүгийн хөрөнгийг шилжүүлэх үүргийг хүлээсэн өдрөөр хүлээн зөвшөөрдөг. Худалдан авалтын бусад бүх гүйлгээг хүлээн зөвшөөрөхдөө компани нь тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд гэрээний оролцогч тал болсон үед бүртгэдэг.

2.3.4 Санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт

Компани нь санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг. (а) хөрөнгийн төлбөрийг авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) компани хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусдад шилжүүлэн өгсөн эсхүл шаардлага хангасан дамжуулан өгөх хэлцэлд оролцсоны үр дүнд (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг үндсэнд нь шилжүүлсэн, (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийн эрхийг шилжүүлээгүй ч авч үлдээгүй гэхдээ хяналтын эрхийг хадгалж байгаа тохиолдолд.

Нөгөө тал хөрөнгийг хараат бус гуравдагч этгээдэд ямар нэгэн хязгаарлалтгүйгээр бүхэлд нь борлуулах бодит боломжгүй байгаа нөхцөлд хяналтыг авч үлдсэнд тооцно.

2.3.5 Санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн өр төлбөрийн төлөх үүргийн хугацаа дууссан, санхүүгийн өр төлбөр төлөх үүргээс чөлөөлөгдсөн болон уг өр төлбөрийг төлөх үүрэг дуусгавар болсон үед санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

2.3.6 Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Санхүүгийн хөрөнгийг анх бүртгэснээс хойш тохиосон нэг буюу олон үйл явдлын ("гарз учруулсан үйл явдлууд") үр дүнд үүссэн бөгөөд санхүүгийн дан ганц эсвэл бүлэг хөрөнгөнөөс ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалын хэмжээ болон цаг хугацаанд нөлөө үзүүлэх үнэ цэнийн алдагдлыг, тухайн нөлөөг баталгаатай тооцох боломжтой тохиолдолд тайлант жилийн орлого, зардалд бүртгэнэ. Хэрэв компани нь тусгайлан дангаар нь үнэлсэн санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнэ нь их, бага хэмжээгээр буурсныг илэрхийлэх бодит нотолгоо байхгүй гэж тодорхойлсон бол тухайн санхүүгийн хөрөнгийг ижил төрлийн зээлийн эрсдлийн шинж чанартай санхүүгийн хөрөнгийн бүлэгт багтаан уг бүлгийн үнэ цэнийн бууралтыг хамтатган үнэлдэг. Компанийн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг тодорхойлоход авч үздэг үндсэн хүчин зүйлс нь тэдгээрийн хугацаа хэтрэлт, мөн барьцаа хөрөнгө (хэрэв байгаа бол)-ийн бодит үнэ цэнийн өөрчлөлт юм. Үнэ цэнэ бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг тодорхойлоход үндэслэл болгодог гол хэмжүүрүүд. Үүнд:

- Гэрээний нөгөө талын аливаа төлбөрийн хугацаа хэтрэлт;
- Гэрээний нөгөө тал санхүүгийн ихээхэн хүндрэлтэй учирдаг болох талаарх мэдээлэл компанид байгаа мэдээллээр нотлогдож байгаа;
- Гэрээний нөгөө талд нөлөөлөл үзүүлэх үндэсний буюу орон нутгийн эдийн засгийн өөрчлөлтийн нөхцөлтэй холбоотойгоор гэрээний нөгөө талын төлбөр гүйцэтгэлд өөрчлөлт гарсан.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.3 Санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)

2.3.6 Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын нөхцөлүүд нь хэлэлцээрийн журмаар дахин хянагдах буюу гэрээний нөгөө талын санхүүгийн хүндрэлтэй холбоотойгоор ямар нэг байдлаар өөрчлөгдсөн бол эдгээр нөхцлийг дахин хянахаас өмнө анхны үр ашигт хүүг ашиглан үнэ цэнийн бууралтыг тодорхойлно. Үүний дараа тухайн санхүүгийн хөрөнгөтэй холбоотой эрсдэл, өгөөж ихээхэн өөрчлөгдсөн бол нөхцөл нь дахин хянагдсан санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасаж, шинэ хөрөнгийг бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ нь анхны болон шинээр хүлээгдэж буй мөнгөн урсгалын дискаунтчилсан үнийн хоорондын зөрүүгээр нотлогдоно.

Үнэ цэнийн бууралтын алдагдлыг үргэлж нөөцийн сангийн дансанд бүртгэж хөрөнгийн бүртгэлийн үнийг хүлээгдэж буй мөнгөн урсгалын (зээлийн хэрэгжээгүй алдагдлыг хасагдуулсан дүнгээр) анхны үр ашигт хүүгээр тооцсон өнөөгийн үнэ цэнэ хүртэл бууруулна. Компанийн мэдэлд байгаа барьцаа төлбөрөөр хамгаалагдсан санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ нь холбогдох барьцааг өмчлөн авч борлуулснаас орж ирэх мөнгөн урсгалыг илэрхийлнэ.

Хэрэв үнэ цэнийн алдагдал дараах үеүдэд буурч, бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш тохиосон бодит үйл явдалтай холбох боломжтой бол, жишээ нь нөгөө талын төлбөрийн чадвар сайжирсан бол нөөцийн сангийн дансыг залруулах замаар өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн алдагдлыг буцааж тухайн жилийн орлого, зардалд бүртгэнэ.

Эргэн төлөгдөх боломжгүй болсон санхүүгийн хөрөнгийг данснаас хасахдаа хөрөнгийг нөхөн төлүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авах бөгөөд алдагдлын хэмжээ тодорхой болсон үед холбогдох алдагдлын сангийн дансанд бүртгэн хасна. Өмнө нь данснаас хассан хөрөнгийн дүн дараа эргэн төлөгдсөн тохиолдолд нөхөн төлөгдсөн дүнгээр тухайн жилийн орлого, зардал дахь үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн дансыг бууруулна.

2.4 Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд кассан дахь бэлэн мөнгө, банкны харилцах болон хугацаат хадгаламж, 3 сар ба түүнээс богино хугацаатай төлөгдөх богино хугацаат болон түргэн хөрвөх бусад хөрөнгө оруулалтыг хамруулна. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.

2.5 Бараа материал

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө, үйлдвэрлэлийн дамжлагад байгаа зүйлс болон үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэх материал, хангамжийн зүйлс хамаарна. Бараа материалыг өртөг, цэвэр боломжит үнийн аль багаар нь тусгана. Цэвэр боломжит үнэ цэнийг тооцоходоо тооцоолол хийх үеийн хамгийн найдвартай бэлэн байгаа нотолгоог авч үздэг.

Бараа материалын дансны үнийн ирээдүйд гарах өөрчлөлт нь зах зээлийн сегмент бүр дэх үнийн өөрчлөлтөөс шалтгаална.

2.6 Урьдчилгаа төлбөр

Урьдчилгаа төлбөр нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч дараагийн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрөгдөх төлбөр, эсвэл хүлээн аваагүй хөрөнгө (бараа материал, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө)-ийн төлбөрөөс бүрдэнэ. Урьдчилгаа төлбөрийг анх хөрөнгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг тухайн зардал нь гарсан тохиолдолд ашиг, алдагдлаар, эсвэл хөрөнгийн өртөгт үл хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Компани урьдчилгаа төлбөрийн дансны үнэд үнэ цэнийн бууралт гарсан эсэхийг хянадаг.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.7 Үндсэн хөрөнгө

Бүх үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрдөг. Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан дараа үеийн зардал нь тухайн хөрөнгийн анх тооцсон бүтээмжийн түвшинг нэмэгдүүлэх замаар компанид эдийн засгийн ирээдүйн өгөөжийг авчрах магадлалтай үед зардлын дүнгээр нь хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлдэг (капиталжуулдаг).

Хүлээн зөвшөөрсний дараах үед үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр илэрхийлдэг. Компани нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо бүхий л үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилтэндээ дахин үнэлгээний загварыг ашиглах, дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлагналын үеийн эцэст бодит үнэ цэнийг тодорхойлохоор тусгасан боловч хэрэгжүүлдэггүй байна.

Хөрөнгө тус бүрийн өртгийг үлдэх өртөг хүртэл дараах ашиглалтын хугацааны туршид шулуун шугмын аргаар элэгдүүлдэг.

Тээврийн хэрэгсэл	10 жил
Тавилга, эд хогшил	3-10 жил
Компьютер, түүний эд анги	2-3 жил

Үндсэн хөрөнгийн дансны дүн, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулсан, эсвэл түүнийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл үл хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (хэрэв байгаа бол), дансны үнийн зөрүүг тайлант жилийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

2.8 Түрээс

Хэрвээ ямар нэгэн төлбөрөөр тогтсон хугацааны туршид тодорхой хөрөнгийг ашиглаж, хянах эрх гэрээнд үүссэн бол тухайн гэрээг түрээсийн гэрээ эсвэл уг гэрээнд түрээсийн зүйл агуулагдсан байна гэж үзнэ.

Компани нь түрээсийн зүйл ба нэмэлтээр нэг эсвэл түүнээс дээш түрээс эсвэл түрээсийн бус зүйл агуулсан гэрээний хувьд түрээсийн зүйлийн гэрээ нэг бүрийн төлбөрийг түрээсийн зүйлийн холбогдох нэг бүрийн үнэ ба түрээсийн бус зүйлийн нэг бүрийн үнийн нийлбэр дээр суурилан хуваарилна.

Компани нь гэрээ эхэлснээс хойш 12 сар ба түүнээс бага хугацаанд түрээслэх худалдан авах нөхцөлгүй түрээсийг богино хугацаат түрээсээр хүлээн зөвшөөрнө. Бага үнэтэй хөрөнгийн түрээсийг мөн адил хүлээн зөвшөөрнө. Богино хугацаат түрээсийн төлбөр ба бага үнэтэй хөрөнгийг түрээсийг шулуун шугмын арга эсвэл бусад системчлэгдсэн аргууд дээр суурилан түрээсийн хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Ашиглах эрхтэй хөрөнгийн өртөгт дараах зүйлс багтана:

- Түрээсийн өр төлбөрийн анх тооцсон дүн;
- Түрээс эхэлснээс эсвэл эхлэхээс өмнө төлсөн түрээсийн төлбөрөөс түрээснээс авсан урамшууллыг хассан дүн;
- Компаниас анх гарсан шууд зардлууд; болон
- Түрээсийн шаардсан нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тодорхой хөрөнгийг задлах ба нүүлгэх, хөрөнгө байрлах газрыг сэргээх эсвэл тухайн хөрөнгийг сэргээхэд компаниас гарсан зардлын тооцоолол.

Ашиглах эрхтэй хөрөнгийг өртгөөс үнэ цэнийн бууралт болон хуримтлагдсан элэгдлийг хассан дүн ба түрээсийн өр төлбөрийн дахин тооцооллын залруулсан дүнгээр тусгадаг. Компани нь түрээсийн гэрээ дуусгавар болох үед тодорхой түрээсийн хөрөнгийн өмчлөлийг шилжүүлэн авах бол ашиглах эрхтэй хөрөнгийг түрээс эхэлсэн өдрөөс эхлэн ашиглагдах

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.8 Түрээс (үргэлжлэл)

хугацаа дуусгавар болох хүртэл элэгдүүлнэ. Өөрөөр заагаагүй бол, ашиглах эрхтэй хөрөнгийг тооцоолсон ашиглагдах хугацаа ба түрээсийн хугацааны аль багаар нь шулуун шугамын аргаар элэгдүүлнэ. Компани нь түрээсийн гэрээ дуусгавар болох үед тодорхой түрээсийн хөрөнгийн өмчлөлийг худалдан авах нөхцөлөө ашиглан шилжүүлэн авах бол ашиглах эрхтэй хөрөнгийн өртөг, үнэ цэнийн бууралт болон хуримтлагдсан элэгдлийн дүнгүүдийг үндсэн хөрөнгөөр бүртгэнэ.

Компани нь түрээс эхэлсэн өдрөөр төлөгдөөгүй байсан түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн. Түрээсийн өр төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцоход Компани нь түрээсийн түвшин түвшин тодорхойлох боломжгүй үед түрээс эхлэх өдрөөр түрээсийн гэрээний нуугдмал хүү мэдэгдэхгүй бол өсөн нэмэгдэх хүүг ашигласан.

Дараах тохиолдолд Компани нь түрээсийн өр төлбөрийг (ашиглах эрхтэй хөрөнгөтэй холбоотой тохирох залруулгын хамт бүртгэж) дахин хэмжинэ:

- Түрээсийн хугацаа өөрчлөгдсөн эсвэл худалдан авах нөхцөлтэй гэрээтэй үед дахин үнэлгээ хийсэн өдрөөрх хорогдуулалтын түвшинг ашиглан хорогдуулсан түрээсийн төлбөрөөр хэмжигдэх түрээсийн өр төлбөрийг дахин үнэлж өөрчлөлт орсон;
- Анх ашигласан хорогдуулалтын түвшинг ашиглан хорогдуулсан түрээсийн төлбөрөөр хэмжигдэх түрээсийн өр төлбөрийг тодорхойлох үед гарсан баталгаат үлдэх өртөгт нөлөөлсөн түрээсийн зах зээлийн боломжит төлбөрийн түрээсийн зах зээлийн түвшин өөрчлөгдсөнөөр түрээсийн төлбөр өөрчлөгдсөн.

Түрээсийн өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд тусад нь толилуулж, холбогдох тодруулгыг мөн тусад нь харуулна.

2.9 Хувьцаат капитал

Хувьцаат капитал нь компанийн гаргасан энгийн хувьцааг илэрхийлэх бөгөөд хүлээн авсан дүнгээс хувьцаа гаргахтай холбоотой шууд зардлыг хассан цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

2.10 Орлого

Эдийн засгийн өгөөж нь компанид орж ирэх нь тодорхой, мөн хэмжих боломжтой үед орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Орлогыг харилцагчаас хүлээн авсан болон хүлээн авах зүйлийн бодит үнэ цэнээр хэмждэг. Орлогыг тооцоолж буй борлуулалтын буцаалт, борлуулалтын хөнгөлөлт, тэдгээртэй ижил төстэй хөнгөлөлтүүдийг хассан цэвэр дүнгээр бүртгэнэ.

Үндсэн үйл ажиллагааны буюу төлбөр тооцооны дэвшилтэт технологийн үйлчилгээ үзүүлсэн сар бүрд нь аккруал суурьт үндэслэн хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

2.11 Зардал

Эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийн бууралтыг найдвартай хэмжих боломжтой ба энэ нь хөрөнгийг багасгах, эсвэл өр төлбөрийг нэмэгдүүлэхээр байвал зардлыг хүлээн зөвшөөрнө.

Төлбөр тооцооны дэвшилтэт технологийн үйлчилгээ үзүүлсний орлогыг хүлээн зөвшөөрөх үед түүнтэй холбоотой зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Үзүүлсэн үйлчилгээний өртөгт үйлчилгээний хураамж, баталгаат мессеж, гүйлгээний хураамж (нэгж шилжүүлэг, мөнгөн шилжүүлэг, банк хоорондын гүйлгээ, оператор, хялбар төлбөр, билл төлбөр, зээлийн шимтгэл г.м)-ийн орлогыг олох үйл ажиллагаатай холбоотой зардлуудыг хамруулан бүртгэдэг. Ерөнхий удирдлагын зардалд ерөнхий ба удирдлагын зардал, борлуулалт ба маркетингийн зардалд борлуулалт ба маркетингтай холбоотой зардлуудыг хамруулан бүртгэдэг.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.12 Ажиллагсдын зардал болон холбогдох шимтгэлүүд

Цалин, хөлс болон цалинтай холбоотой бусад зардлуудыг ажилтны хөдөлмөр эрхэлсэн тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Эзлжийн амралт, бусад богино хугацаат тэтгэмжийг олгохоор шийдвэрлэсэн үед нь зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд хуулийн дагуу заавал тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн даатгалын сангуудад шимтгэл төлдөг. Эдгээр даатгалын шимтгэлийг цалин, хөлсийг тооцсон үе бүрд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

2.13 Зээлийн зардал

Бэлтгэл шаардагдах хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил, эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн өртгийг капиталжуулна. Компани бусад зээлийн өртгийг гарсан тайлант үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө. Бэлтгэл шаардагдах хөрөнгө гэдэг нь түүнийг зориулалтаар нь ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгоход их хэмжээний хугацаа зарцуулдаг хөрөнгийг хэлэх ба уг хөрөнгийг ашиглах ба борлуулахад бэлэн болгох хүртэлх хугацаанд хүүгийн зардлыг хөрөнгийн өртөгт оруулдаг.

2.14 Гадаад валютын ажил гүйлгээ

Санхүүгийн тайлангаа өөрийн үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн тэмдэгт болох "Монгол төгрөг"-өөр тайлагнадаг. Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг анх хүлээн зөвшөөрч бүртгэхдээ ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгж рүү хөрвүүлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлс (мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр)-ийг тайлагналын өдөр хаалтын ханшаар дахин хөрвүүлж тайлагнадаг. Мөнгөн зүйлсийг хаалтын ханшаар илэрхийлснээс үүссэн олз ба гарзыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Түүхэн өртгөөрөө хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг хаалтын ханшаар дахин хөрвүүлдэггүй бөгөөд ажил гүйлгээ гарсан өдрийн ханшаар нь тайлагнадаг.

2.15 Болзошгүй өр төлбөр ба хөрөнгө

Аж ахуйн нэгжийн бүрэн хяналтаас гадуурх нэг болон түүнээс дээш ирээдүйн үйл явдал тохиолдох, эс тохиолдохоос хамаарч үүсэх эсэх нь тодорхойлогддог тул болзошгүй өр ба болзошгүй хөрөнгийг бүртгэдэггүй. Эдийн засгийн өгөөжийг агуулсан нөөцийн гадагш урсгал гарах магадлал маш бага биш л бол бүх тохиолдолд болзошгүй өр төлбөрийг санхүүгийн тайланд нэмж тодруулна. Харин эдийн засгийн өгөөж орж ирэх өндөр магадлалтай үед л болзошгүй хөрөнгийг санхүүгийн тайланд нэмж тодруулна.

2.16 Орлогын албан татвар

Орлогын татварын зардал нь тайлант жилийн татварын зардал, хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэнэ.

2.16.1 Тайлант жилийн орлогын албан татвар

Тайлагналын өдрөөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хууль (цаашид "татварын хууль" гэх)-ийн дагуу татвар ногдуулах орлого, төлбөл зохих орлогын албан татварын дүнг тооцоолсон. Татварын хуулийн болон СТОУС-ын үзэл баримтлалын ялгаатай байдлын улмаас татвар ногдуулах орлогын дүнг тодорхойлохдоо СТОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч бүртгэсэн зарим орлого, зардлын дүнг огт авч үздэггүй (тухайлбал, баримтаар нотлогдохгүй зардал), эсвэл уг хуульд заасан шаардлагын дагуу түр хойшлуулан авч үздэг (тухайлбал, мөнгөн зүйлсийг хаалтын ханшаар дахин хөрвүүлснээс үүссэн ханшийн зөрүүний олз ба гарз).

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.16 Орлогын албан татвар (үргэлжлэл)

2.16.2 Хойшлогдсон татвар

Хойшлогдсон орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн хоёрын хоорондын түр зөрүүний дүнгээс тайлан тэнцлийн аргыг хэрэглэн тооцдог. Бараг бүх (маш бага түр зөрүүнээс бусад) татвар ногдох болон хасагдах түр зөрүүнээс тайлагналын өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа татварын хуулиуд ба татварын хувиар хойшлогдсон татварын өр болон хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Түр зөрүүг арилсан үеийн татвар ногдуулах орлогыг тохируулах байдлаар үл хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлагналын өдөр бүр хянаж үздэг ба уг хөрөнгийг бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед дансны үнийг бууруулдаг. Үл хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон татварын хөрөнгийг тайлагналын өдөр бүр дахин үнэлж үздэг ба хойшлогдсон татварын хөрөнгийг ашиглах боломжтой орлого ирээдүйд орж ирэх магадлалтай үед хүлээн зөвшөөрдөг.

2.17 Холбоотой тал

Компани болон түүнтэй холбоотой этгээдүүдийн хооронд ажил үйлчилгээ эсвэл үүрэг хариуцлага шилжүүлэхдээ төлбөр нэхэмжилсэн эсэхээс үл хамааран тэдгээрийн хооронд хийгдсэн ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ гэнэ.

Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд компанитай холбоотой гэж үзнэ.

- Компанийг шууд эсвэл хамтран хянадаг
- Компанийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг
- Компанийн удирдах ажилтан

Хэрэв дараах нөхцлийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгжийг компанитай холбоотой гэж үзнэ.

- Тухайн аж ахуйн нэгж болон компани нь нэг бүлэг аж ахуйн нэгжийн бүрэлдэхүүнд багтаж байвал. Өөрөөр хэлбэл, толгой компани охин компани болон нэг толгой компанид багтдаг охин компаниуд бүгд бусадтайгаа холбоотой тал юм;
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан бүлгийн нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол;
- Хоёр компани хоёулаа гуравдагч этгээдийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол;
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан үйлдвэр ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани бол;
- Тухайн аж ахуйн нэгж нь компани эсвэл компанитай холбоотой аж ахуйн нэгжийн аль нэгнийх нь ажилчдын тэтгэвэр тэтгэмжинд зориулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө байгаа бол;
- Тухайн аж ахуйн нэгж нь дээр дурдсан холбоотой талаар тодорхойлогдсон хувь хүний шууд эсвэл хамтарсан хяналтан дор байх;
- Компанийг шууд эсвэл хамтран хянадаг этгээд нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд их хэмжээний нөлөөтэй байх, тухайн аж ахуйн нэгжийн, эсвэл түүний толгой компанийн удирдах ажилтан.

3. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, төсөөллүүд

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнагдсан хөрөнгө, өр төлбөрийн дүн, болзошгүй хөрөнгө өр төлбөрийн тодруулга болон тайлант үед хүлээн зөвшөөрөгдсөн орлого, зардлын дүнд тус тус нөлөөлдөг. Ирээдүйд гарах бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг байнга хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг өөрчлөлт хийгдсэн тайлант үе болон ирээдүйн тайлант үеүдэд тус тус тусгадаг.

3.1. Тасралтгүй үйл ажиллагаа

Компанийн удирдлагын зүгээс компанийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварыг үнэлж үзсэн бөгөөд компани нь ойрын ирээдүйд бизнесээ тасралтгүй явуулж чадах хэмжээний нөөцтэй гэж дүгнэсэн. Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварын талаар эргэлзээ төрүүлж болох аливаа нэг материаллаг тодорхойгүй байдал байхгүй гэж компанийн удирдлага үзэж байна. Иймд санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэсэн.

3.2. Биет бус хөрөнгийн дахин үнэлгээ

Биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө анхны өртгөөр бүртгэх ба дараа үеийн хэмжилтийг нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо ямар загвар ашиглахыг тодорхой заагаагүй боловч биет бус хөрөнгийг дахин үнэлүүлсэн байна. Компани нь мэргэшсэн үнэлгээчнээр хөрөнгүүдээ үнэлүүлсэн ба хөрөнгийн үнэлгээний таамаглал болон үнэлгээний аргад оруулсан томоохон өөрчлөлт нь хөрөнгийн дахин үнэлгээний нөөцийн дүнд нөлөөлнө.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба толилуулгад орсон өөрчлөлтүүд

4.1 Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн шинэчлэгдсэн СТОУС болон шинэ тайлбарууд

Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан 2025 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн СТОУС-ын өөрчлөлтүүдийг тайлант жилд хэрэгжүүлсэн.

Хэрэгжих хугацаа	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд
2025 оны 6 сарын 23	СТОУС-ын Практик мэдэгдэл 1: Удирдлагын тайлан

Дээрх стандартуудын нэмэлт өөрчлөлтүүд нь Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлээгүй болно.

4.2 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй СТОУС-ууд

Шинээр батлагдаж, хэвлэн нийтлэгдсэн боловч хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хугацаа нь хараахан болоогүй байгаа стандарт болон стандартуудын нэмэлт өөрчлөлтүүдийг доор жагсаасан бөгөөд шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт болон тайлбарууд нь ирэх тайлант жилүүдэд хүчин төгөлдөр үйлчилж эхлэх бөгөөд компани эдгээрийг зрт хэрэгжүүлээгүй.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба толилуулгад орсон өөрчлөлтүүд (үргэлжлэл)

4.2 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй СТОУС-ууд (үргэлжлэл)

Хэрэгжих хугацаа	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд
Тодорхойгүй	СТОУС 10, НББОУС 28 Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани, хамтарсан компанийн хооронд худалдсан эсвэл хандивласан хөрөнгийн нэмэлт өөрчлөлт
2026 оны 01 сарын 01	СТОУС 9 "Санхүүгийн хэрэглүүр" СТОУС 7 "Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга"
2027 оны 01 сарын 01	СТОУС 18: Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга,
2027 оны 01 сарын 01	СТОУС 19: Олон нийтийн үүрэг хариуцлага хүлээгээгүй охин компаниуд: Тодруулга
2027 оны 01 сарын 01	НББОУС 21-д оруулсан нэмэлт өөрчлөлт: Хэт инфляцитай эдийн засгийн үеийн тайлагналын валютад хөрвүүлэх нь

Компани нь эдгээр стандартуудыг хэрэгжүүлэлтээс үүсэх нөлөөллийг бүрэн хэмжээнд хараахан үнэлээгүй бөгөөд уг стандартуудын нэмэлт өөрчлөлтүүд компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

5. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Санхүүгийн тайланд толилуулсан мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байдалтай байна.

Төгрөгөөр	2025	2024
Касс дахь мөнгө	150,913	198,285
Банкин дахь мөнгө	145,900,218	275,142,246
Хадгаламж-Ард, Ариг	536,234,547	498,997,500
	682,285,678	774,338,031

Мөнгөн ба түүнтэй адилтгах хөрөнгийн 73.3 хувийг Ард Активын Хадгаламжийн дансанд, 5.3 хувийг Ариг банкны хадгаламжийн дансанд байршуулсан. Банкин дахь мөнгөн хөрөнгийн 19.4 хувь буюу 132,160.1 мянган төгрөгийг Худалдаа хөгжлийн банкны дансанд, 1.2 хувь буюу 8,381.4 мянган төгрөгийг Ариг банкны дансанд, 0.8 хувь буюу 5,358.7 мянган төгрөгийг Хас банкны данснуудад тус тус байршуулсан байна.

6. Дансны авлага болон бусад авлага

Санхүүгийн тайланд толилуулсан авлагын үлдэгдэл дараах байдалтай байна.

Төгрөгөөр	2025	2024
Дансны авлага	614,469,134	156,830,801
НӨАТ-н хэрэгжээгүй авлага	10,542,000	150,000
Компани хоорондын тооцооны авлага	1,723,994,048	1,721,493,053
Бусад авлага (байгууллага)	1,971,218,173	1,961,069,865
Хүүгийн авлага	61,676,712	61,675,833
	4,381,900,067	3,901,219,552

6. Дансны авлага болон бусад авлага (үргэлжлэл)

Компани хоорондын тооцооны авлага дансанд тусгагдсан 1,723,994.0 мянган төгрөгийн авлага нь "МООТ Колл" ХХК-аас авах 58,789.0 мянган төгрөгийн 1,670,000 АСО-Ардхойныг дараа тооцоогоор "МООТ Колл" ХХК-д түр зээлсэнтэй холбоотой үүссэн авлага, 1,465,205.0 мянган төгрөгийн авлага нь "Скоп Аллианс" ХХК-иас эргэн авах нөхцөлтэйгөөр бусад харилцагчдын өр төлбөрийг барагдуулсан байна. Үлдсэн 200,000.0 мянган төгрөгийн авлага нь Ард санхүүгийн нэгдлээс авах "Өндөрхаан" ХК-ийн 2 хувийн 2,238 ширхэг хувьцааны үнэлгээний дүн бөгөөд хэрэгжсэн үед нь урт хугацаат хөрөнгө оруулалт данс руу шилжүүлэх хувьцаагаар авах авлага байна. Бусад авлага (байгууллага) дансанд тусгагдсан 1,971,218.2 мянган төгрөгийн 1,900,000.0 мянган төгрөг нь Ард Кредит ББСБ ХК-аас авах жилийн 16 хувийн хүүтэй богино хугацаатай зээл, 65,208.0 мянган төгрөг нь "Шангри-Ле Улаанбаатар" ХХК-иас түрээсэлж буй объектын түрээсийн барьцаа төлбөр байна. Хүүгийн авлага дансанд тохируулах бичилтээр бүртгэсэн 61,676.7 мянган төгрөгийн авлагын 2,498.6 мянган төгрөг нь "Ард Кредит ББСБ" ХК-нд олгосон 1,900,000.0 мянган төгрөгийн зээлийн тайлант хугацааны хүү, 438.4 мянган төгрөг нь "Ард Актив ХЗХ" ХХК-н хадгаламжид байршуулсан мөнгөний тайлант хугацааны хүү, үлдсэн 58,739.7 мянган төгрөг нь "Ард Лизинг" ХХК-н гаргасан 12 сарын хугацаатай 16 хувийн хүүтэй 1,900,000.0 мянган төгрөгийн бондын хүү байна.

7. Бараа материал

Санхүүгийн тайланд толилуулсан бараа материалын үлдэгдэл дараах байдалтай байна.

Төгрөгөөр	2025	2024
Агуулахад буй хангамжийн материал	535,760	796,057
Ашиглалтад буй хангамжийн материал	793,575	82,401
	1,329,335	878,458

Агуулахад буй хангамжийн материалын 57.7 хувь буюу 309.0 мянган төгрөгийг Дросель /өдрийн гэрэл/ үлдсэн 42.3 хувийг бичиг хэрэг, хангамжийн материал эзэлж байна.

8. Урьдчилж төлсөн зардал, тооцоо

Санхүүгийн тайланд толилуулсан урьдчилж төлсөн зардлын үлдэгдлийг доор үзүүлэв.

Төгрөгөөр	2025	2024
Урьдчилж төлсөн зардал	25,908,467	8,626,911
Урьдчилж төлсөн тооцоо	525,058,843	422,258,844
	550,967,310	430,885,755

Тайлант онд урьдчилж төлсөн зардал данс 91,738.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 74,456.8 мянган төгрөгөөр буурсан байна. Урьдчилж төлсөн тооцоо дансанд тайлагнагдсан 525,058.8 мянган төгрөгийн 70.5 хувь буюу 388,275.0 мянган төгрөг нь "ГрэйпСити Монгол" ХХК-тай хийгдсэн гэрээний дагуух хүлээн авсан системийн төлбөр боловч компани нь ашиглаж эхлээгүй бөгөөд ашиглаж эхэлсэн хугацаанаас хөрөнгийн данс руу шилжүүлнэ. 19.1 хувь буюу 105,000.0 мянган төгрөгийн урьдчилж төлсөн тооцоо нь "ГрэйпСити Монгол" ХХК-тай байгуулсан ЛА-25/52(02), ЛА-25/52(03) тоот гэрээний дагуу программын хөгжүүлэлтийн ажлаас үүссэн дүн байна. Үлдсэн 5.8 хувь буюу 31,783.8 мянган төгрөг нь "Ард Секоритиз УЦК" ХХК-д төлсөн урьдчилгаа төлбөр байна.

9. Бусад эргэлтийн хөрөнгө

Санхүүгийн тайланд толилуулсан бусад эргэлтийн хөрөнгө үлдэгдлийг доор үзүүлэв.

Төгрөгөөр	2025	2024
Богино хугацаат хөрөнгө оруулалт /Бонд/	1,900,000,000	1,900,000,000
	1,900,000,000	1,900,000,000

2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр "Ард Секюритиз УЦК" ХХК-тай байгуулсан Л23-12/50 тоот гэрээний дагуу "Ард Лизинг" ХХК-ийн хаалттай бондоос нэг бүр нь 100.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй 10,000 ширхэг бондыг 12 сарын хугацаатай жилийн 16 хувийн хүүтэй худалдан авсан. Мөн 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдөр нэмж Л24-02/26 тоот гэрээний дагуу нэг бүр нь 100.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй 9,000 ширхэг бондыг 12 сарын хугацаатай 16 хувийн хүүтэй худалдан авсан. Эдгээр гэрээний хугацаа дууссан тул дахин бонд худалдан авч 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Л25-02/01 тоот гэрээний дагуу, 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Л25-12/49 тоот гэрээний дагуу тус тус 12 сарын хугацаатай 16 хувийн хүүтэй гэрээ хийгдсэн байна.

10. Үндсэн хөрөнгө

Санхүүгийн тайланд толилуулсан үндсэн хөрөнгийн үлдэгдэл дараах байдалтай байна.

Төгрөгөөр	Барилга, байгууламж	Тавилга, эд хогшил	Мэдээлэл боловсруулах тех/хэрэгсэл, төхөөрөмж	Техник, тоног төхөөрөмж	Компьютер, дагалдах хэрэгсэл	Бусад үндсэн хөрөнгө	Нийт
Өртгийн дүн							
2024.12.31	4,570,000	31,961,698	943,300,030	18,900,000	143,297,042	1,283,614	1,143,312,384
Нэмэгдсэн	-	660,421	5,227,273	-	204,545	450,000	6,542,239
Хасагдсан	4,570,000	430,000	93,350,000	18,900,000	5,485,364	310,000	104,146,364
2025.12.31	-	32,192,119	855,177,303	-	138,015,224	1,423,614	1,026,808,260
Хуримтлагдсан элэгдэл							
2024.12.31	558,555	9,107,783	299,680,029	11,004,400	67,404,090	299,315	388,054,172
Нэмэгдсэн	185,772	3,781,863	104,105,923	3,860,000	36,943,716	224,674	148,901,948
Хасагдсан	744,326	242,536	93,350,000	14,864,400	4,087,364	108,949	113,197,577
2025.12.31	-	12,647,107	310,435,953	-	100,260,443	415,040	423,758,543
2024.12.31	4,011,445	22,853,915	643,620,001	7,895,600	75,892,952	984,299	766,268,212
2025.12.31	-	19,645,012	544,741,350	-	37,754,781	1,008,574	603,049,717

11. Биет бус хөрөнгө

Санхүүгийн тайланд толилуулсан биет бус хөрөнгийн үлдэгдэл дараах байдалтай байна.

Төгрөгөөр	Бусад биет бус хөрөнгө	Нийт
Өртөг эсвэл дахин үнэлэгдсэн дүн		
2024 оны 12 сарын 31	5,039,684,827	5,039,684,827
Нэмэгдсэн	80,818,182	80,818,182
2025 оны 12 сарын 31	5,120,503,009	5,120,503,009
Хуримтлагдсан элэгдэл		
2024 оны 12 сарын 31	104,766,680	104,766,680
Нэмэгдсэн	7,440,846	7,440,846
2025 оны 12 сарын 31	112,207,526	112,207,526
Дансны үнэ		
2024 оны 12 сарын 31	4,934,918,147	4,934,918,147
2025 оны 12 сарын 31	5,008,295,483	5,008,295,483

12. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Санхүүгийн тайланд толилуулсан урт хугацаат хөрөнгө оруулалт үлдэгдэл дараах байдалтай байна.

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
МОСТ Колл ХХК	450,000,000	450,000,000
Дижитал Распо ХХК	550,500,000	50,500,000
Өндөр хаан ХК	19,951,787	19,951,787
Скоп Аллианс ХК	3,000,001	3,000,001
МОСТ Паркинг ХХК	290,000,000	150,000,000
Ард кредит ББСБ ХК	1,154,643,064	1,154,643,064
	2,468,094,852	1,828,094,852

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансанд тайлагнагдсан 450,000.0 мянган төгрөг нь "МОСТ Колл" ХХК-ийн 45 хувийг эзэмших урт хугацааны хөрөнгө оруулалт байна. 2024 оны 10 сарын 25-ны өдрийн "Дижитал Распо" ХХК-д нэмэлт хөрөнгө оруулалт хийх тухай 18/24 тогтоолын дагуу тайлант хугацаанд "Дижитал Распо" ХХК-ийн нэмж гаргасан хувьцаанаас 5003 ширхэг хувьцааг нэгжийг нь 50.0 мянган төгрөгөөр худалдан авч, Бари групп ХХК-с урьдчилан шилжүүлэн авсан 4997 ширхэг хувьцааг нэгжийг нь 50.0 мянган төгрөгөөр нөхөн оруулж нийт 500,000.0 мянган төгрөгөөр хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн байна. "Өндөрхаан" ХК-тай байгуулсан В-11/23 гэрээний дагуу 200,000.0 мянган төгрөгийн 2 хувийн 2,238 ширхэг хувьцааны үнэлгээний дүн бөгөөд хэрэгжсэн үед нь урт хугацаат хөрөнгө оруулалт данс руу шилжүүлэхээр байгаа бөгөөд одоогоор хэрэгжсэн дүн нь 19,951.8 мянган төгрөг байна. 150,000.0 мянган төгрөг нь "МОСТ Паркинг" ХХК-ийн 33.3 хувь болох 50 ширхэг 600,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын гэрээний дагуу оруулсан дүн байна. "Ард Кредит ББСБ" ХК-н нэгж нь 106 төгрөгийн үнэтэй нийт 10,785,009 ширхэг хувьцааг 1,143,210.9 мянган төгрөгөөр худалдан авч хөрөнгө оруулсан байна.

13. Бусад эргэлтийн бус хөрөнгө

Санхүүгийн тайланд толилуулсан бусад эргэлтийн бус хөрөнгийн үлдэгдлийг дараах байдалтай байна.

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
Виртуал хөрөнгө - Ардкойн	3,607,458,782	2,745,139,043
	3,607,458,782	2,745,139,043

Тайланд онд Ардбит ХХК -д төлөх өрөө хааж 26,759.7 мянган төгрөг буюу 914,325 ширхэг АСО-Ардкойныг зарлагдаж, МОСТ Колл ХХК-д 1,670,000 ширхэг буюу 61,289.0 мянган төгрөгийн АСО-Ардкойныг дараа тооцоогоор олгосон байна. Мөн ММ үйлчилгээг таниулан сурталчлах урамшуулалд 80,000 ширхэг АСО-Ардкойныг зарцуулсан байна. 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл 83,121,170.09 ширхэг койныг Айдакс платформын хаалтын ханш болох 43.4 төгрөгөөр тэгшитгэсэн байна.

14. Дансны ба бусад өглөг

Санхүүгийн тайланд толилуулсан дансны ба бусад өглөгийн үлдэгдэл дараах байдалтай байна.

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
Дансны өглөг	12,077,712	6,228,907
Цалингийн өглөг	66,030,996	27,629,903
Компани хоорондын тооцооны өглөг	92,400,000	168,937,574
Бусад өглөг/ Байгууллага/	211,922,959	237,122,268
Бусад өглөг/ Хувь хүн/	4,398,900	3,129,390
Бусад өглөг/ Сахилгын сан/	3,239,758	4,890,918
Бусад өглөг - Урьдчилж тооцсон хүүгийн татварын өглөг	6,167,671	6,167,583
	396,237,997	454,106,543

Компани хоорондын тооцооны өглөгийн үлдэгдлийн 92,400.0 мянган төгрөг нь "ГрэйпСити Монгол" ХХК-тай хийсэн ЛА-25/52(02) тоот Програм хангамж нийлүүлэх нэмэлт гэрээний дагуу өгөх өглөг байна. Бусад өглөг /Байгууллага/-ийн 98.6 хувь буюу 207,803.9 мянган төгрөг нь "Ард санхүүгийн нэгдэл" ХК-д Өндөр хааны хувьцаа худалдан авалттай холбоотойгоор өгөх өглөг байна.

15. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг

Санхүүгийн тайланд толилуулсан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн үлдэгдэл дараах байдалтай байна.

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
ААНОАТ-ын өглөг	22,777,887	14,637,860
ХХОАТ-ын өглөг	11,351,722	12,674,616
Оршин суугч биш этгээдээс суутгасан НӨАТ	170,800	121,389
НӨАТ-ын өглөг	9,177,080	22,756,842
НДШ өглөг	8,577,701	4,530,395
Татварын алданги торгууль	-	30,959,027
	52,055,190	85,680,129

16. Хойшлогдсон татварын өр

Санхүүгийн тайланд толилуулсан хойшлогдсон татварын өр дараах байдалтай байна.

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
Хойшлогдсон татварын өр	111,382,368	17,157,119
	111,382,368	17,157,119

2025 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл 83,121,170.09 ширхэг ардквойныг Айдакс платформын хаалтын ханш болох 43.4 төгрөгөөр тэгшитгэсэнтэй холбоотойгоор үүссэн хойшлогдсон татварын өр байна.

17. Хувьцаат капитал

Санхүүгийн тайланд толилуулсан хувьцаат капитал дараах байдалтай байна.

<i>Төгрөгөөр</i>	Хувьцааны тоо		Хувьцаат капитал	
	2025	2024	2025	2024
Эхний болон эцсийн үлдэгдэл	485,969,700	485,969,700	4,859,697,000	4,859,697,000

2024 болон 2025 оны 12 сарын 31-нээрх компанийн 4,859,697.0 мянган төгрөгийн хувьцаат капитал нь нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 485,969,700 ширхэг хувьцаанаас бүрдэж байна.

18. Нэгж хувьцаанд ногдох ашиг

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
Тайлант хугацааны ашиг (алдагдал)	1,076,561,322	922,824,183
Энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо	485,969,700	485,969,700
Нэгж хувьцаанд ногдох ашиг	2.22	1.90

Тайлант жилд хорогдуулсан энгийн хувьцаа байхгүй болно.

Нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг компанийн жилийн туршид эргэлтэнд байгаа хувьцааны жигнэсэн дундажаар тооцоолно. Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашгийг тооцоолохдоо боломжит бүх хувьцааг хорогдуулах нөлөөтэй хөрвүүлснээр жигнэсэн дундаж хувьцааны жигнэсэн дундажийг тохируулна. Үүний нэгэн адил цэвэр ашгийг хөрвүүлэлтийн үр нөлөөг (татварыг хассан) авч үзэхийн тулд залруулга хийнэ. Энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоо 485,969,700 ширхэг гэж тооцоолов.

Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан нэгж хувьцаанд ногдох ашиг нь энгийн хувьцааны нэгж хувьцааны ашигтай харьцуулахад энгийн хувьцаанаас өөр бусад хувьцаа байхгүй учир адилхан байна.

19. Халаасны хувьцаа

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
Халаасны хувьцаа	272,160,007	272,160,007
	272,160,007	272,160,007

2024 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 17/24 тоот тогтоолын дагуу 6,818,182 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 39.6 төгрөгөөр эргүүлэн худалдан авсан байна. Буцаан худалдан авах үнийг "Улаанбаатар үнэт цаасны Бирж" ХК-иас гаргасан хувьцааны жигнэсэн дундаж ханшны мэдээллийг ашигласан байна.

20. Нэмж төлөгдсөн капитал

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
Нэмж төлөгдсөн капитал	6,795,689,845	6,795,689,845
	6,795,689,845	6,795,689,845

21. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
ҮХ-ийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,186,049,897	3,299,884,178
	4,186,049,897	3,299,884,178

2025 онд хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс нь хөрөнгийг борлуулах болон данснаас хасаж актлахтай холбоотойгоор 116,275.6 мянган төгрөгөөр буурсан байна. Виртуал хөрөнгө Ардкойныг 2024 оны 12 дугаар сарын 31-нээр үлдэгдэл 85,785,594.76 ширхэг койныг Айдакс платформын хаалтын ханш болох 32 төгрөгөөр, 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл 83,121,170.09 ширхэг ардкойныг Айдакс платформын хаалтын ханш болох 43.4 төгрөгөөр тэгшитгэсэнтэй холбоотой үүсэн бодит үнэ цэнийн нэмэгдэл 1,002,441.3 мянган төгрөгөөр үүссэн байна.

22. Эздийн өмчийн бусад хэсэг

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
Эздийн өмчийн бусад хэсэг	-	154,414,071
	-	154,414,071

23. Борлуулалтын орлого (цэвэр)

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
Үйлчилгээний орлого- Сарын хураамж /ББСБ/ҮЦК/	14,980,750	5,150,000
Үйлчилгээний орлого - Гүйлгээний хураамж, шимтгэл	2,240,184,638	1,776,957,869
Үйлчилгээний орлого - Мессеж мэдэгдлийн хураамж	46,255,862	62,567,235
Үйлчилгээний орлого - Зээлийн шимтгэл	402,336,500	283,006,989
Үйлчилгээний орлого - Шинэ хэрэглэгчийн бүртгэлийн хураамж	19,119,718	10,172,920
Үйлчилгээний орлого - ҮЦ-ны захиалгын биелэлт	4,843,226	1,642,500
Үйлчилгээний орлого - Сарын үйлчилгээний хураамж /Банк/	54,000,000	54,000,000
Бусад борлуулалт	33,262,575	193,153,493
	2,814,983,269	2,386,651,006

24. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
ББӨ-/Мобиком-баталгаат смс/	15,132,909	19,551,193
ББӨ-/Юнител-баталгаат смс/	18,421,554	13,545,355
ББӨ-/Жи-Мобайл-баталгаат смс/	489,682	595,427
ББӨ-/Скайтел-баталгаат смс/	2,490,725	1,891,100
ББӨ-/Онлайн баталгаат смс/	90,644	41,291
ББӨ-/Ондо баталгаат смс/	275,079	456,193
ББӨ-/AWS мэдэгдэл/	716,723	3,002,777
ББӨ-Тест	18,000	415,893
ББӨ-/Бусад/	13,531,854	-
Үйлчилгээний хураамж	49,983,815	46,256,557
	101,150,985	85,755,786

25. Хүүгийн болон бусад орлого

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
Хүүгийн орлого	693,732,494	696,117,235
	693,732,494	696,117,235

26. Бусад олз ба (гарз)

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, (гарз)	2,351	81,478
Үндсэн хөрөнгө ашиглалтаас хассаны олз, (гарз)	(2,305,621)	1,838,636
Виртуал хөрөнгө данснаас хассаны олз, (гарз)	5,350,251	-
	3,046,981	1,920,114

27. Борлуулалт, маркетингийн зардал

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
Ажилчдын цалингийн зардал	316,581,829	338,445,605
Аж ахуй нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	39,540,244	42,399,362
Шуудан холбооны зардал	17,991,608	6,392,998
Элэгдэл хорогдлын зардал	12,351,466	16,923,322
Түрээсийн зардал	112,294,090	77,942,353
Сургалтын зардал	2,326,482	5,046,500
Томилолтын зардал	3,487,671	-
Зар сурталчилгааны зардал	80,485,363	39,075,953
Ажиллагсад олгосон шагнал	-	8,419,111
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	25,000,000	-
Хангамжийн зардал	19,918,826	20,570,203
Бусад зардал	9,348,719	6,846,185
	639,326,298	562,061,592

28. Ерөнхий ба удирдлагын зардал, бусад зардал

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
Ажилчдын цалингийн зардал	726,471,856	639,810,546
Аж ахуй нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	82,500,800	72,625,948
Бичиг хэргийн зардал	800,105	1,343,163
Шуудан холбооны зардал	33,486,151	35,334,388
Мэргэжлийн үйлчилгээ	61,303,955	166,864,141
Засварын зардал	99,488	291,454
Элэгдэл хорогдлын зардал	143,898,789	159,938,571
Түрээсийн зардал	147,231,804	112,434,683
Тээврийн зардал	64,560	53,442
Томилолтын зардал	10,463,014	-
Банкны үйлчилгээний зардал	234,014	320,555
Программ хангамжийн зардал	206,699,734	105,576,073

28. Ерөнхий ба удирдлагын зардал, бусад зардал (үргэлжлэл)

Хангамжийн материалын зардал	24,293,681	22,197,655
Сургалтын зардал	2,341,473	-
Ажиллагсдад олгосон шагнал	-	10,369,334
Удирдлагын үйл ажиллагааны зардал	67,930,708	32,208,799
Тусламж, тэтгэмжийн зардал	10,440,000	4,980,000
Бусад зардал	16,744,010	27,196,795
	1,535,004,142	1,393,545,547

29. Бусад зардал

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
Тэмдэглэлт баяр ёслолын арга хэмжээ	21,693,056	16,398,423
Спорт, эрүүл мэндийн арга хэмжээ	4,580,000	3,800,000
Ажиллагсдад олгосон шагнал	7,780,000	-
Системийн алдаанаас үүдсэн зардал	7,811,276	-
Үйл ажиллагааны бус бусад зардал	2,539,751	3,170,719
	44,404,083	23,369,142

30. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл

Тус компани нь доор дурдсан аж ахуйн нэгжүүдтэй холбоотой талууд юм.

Холбоотой талуудын нэр	Холбоо хамаарал
Иргэн Сүхдорж Оргил	Гүйцэтгэх захирал
Иргэн Авир Сүхдорж	Хувьцаа эзэмшигч
Ардын тэтгэврийн данс ХХК	Хувьцаа эзэмшигч
АРД ЛИЗИНГ ХХК	Хувьцаа эзэмшигч
Эйч Ви Эл Эл ХХК	Хувьцаа эзэмшигч
Ард секюритиз ҮЦК ХХК	Хувьцаа эзэмшигч
ГрэйпСити Монгол ХХК	Хувьцаа эзэмшигч
Дананжав Эрдэнэчимэг	Хувьцаа эзэмшигч
Балбар Мэдрээ	Хувьцаа эзэмшигч
Данзандорж Баясгалан	Хувьцаа эзэмшигч
Түвдэндорж Отгонбаяр	Хувьцаа эзэмшигч
Норжий Урнаа	Хувьцаа эзэмшигч
Жуулхүү Цолмонбаатар	Хувьцаа эзэмшигч
Даваасамбуу Гэрэлтуяа	Хувьцаа эзэмшигч
Сэргэлэн Мөнх-Отгон	Хувьцаа эзэмшигч
Баттөмөр Баярцэцэн	Хувьцаа эзэмшигч
Батчулуун Наранчулуун	Хувьцаа эзэмшигч
Бямбадорж Мөнхцэцэг	Хувьцаа эзэмшигч
Балданжамц Ганболд	Хувьцаа эзэмшигч
Чулуунбаатар Мөнхцэцэг	Хувьцаа эзэмшигч
Чулуун Ганхуяг	Хувьцаа эзэмшигч
ЖИ ЭС БИ КАПИТАЛ ББСБ ХХК	Хувьцаа эзэмшигч
Өндөрхаан ХХК	Хараат компани

30. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл (үргэлжлэл)

МОСТ Колл	Хараат компани
МОСТ Паркинг	Хараат компани
Скоп алианс	Хараат компани
Дижитал Рэспо	Хараат компани
Ард санхүүгийн нэгдэл ХК	Хувьцаа эзэмшигч
Ард Бит ХХК	Хувьцаа эзэмшигчийн холбоотой компани
Ард Даатгал ХХК	Хувьцаа эзэмшигчийн холбоотой компани
Ард Кредит ХХК	Хувьцаа эзэмшигч болон МОСТ багахан хувьтай
Ард Пропертиз ХХК	Хувьцаа эзэмшигч

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудтай дараах үлдэгдэлтэй байна.

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
Хувьцаа эзэмшигчдээс авах авлага	2,636,193,895	2,270,798,775
Хараат компаниас авах авлага	1,523,994,047	1,445,547,848
Авлагын үлдэгдэл	4,160,187,942	3,716,346,623
Хувьцаа эзэмшигчдэд өгөх өглөг	300,203,952	402,501,187
Хараат компанид өгөх өглөг	-	1,000,000
Өглөгийн үлдэгдэл	300,203,952	403,501,187

Холбоотой талуудтай дараах санхүүжилтийн ажил гүйлгээг хийсэн байна.

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
<u>Олгосон зээл, хүү:</u>		
Хувьцаа эзэмшигчдэд	-	4,646,715,625
Хараат компанид	81,133,000	1,445,547,847
<u>Олгосон зээлээс төлсөн дүн, хүү:</u>		
Хувьцаа эзэмшигчдэд	75,945,205	
Хараат компанид	2,686,800	4,021,917,808

Холбоотой талуудтай дараах ажил гүйлгээг хийсэн байна.

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
<u>Авсан бараа ажил үйлчилгээ, хүү:</u>		
Хувьцаа эзэмшигчдээс	-	233,348,706
Хараат компаниас	-	12,400,000
<u>Авсан бараа ажил үйлчилгээ, хүүгээс төлсөн:</u>		
Хувьцаа эзэмшигчдэд	-	456,635,430
Хараат компанид	-	12,500,000

Холбоотой талуудтай дараах борлуулалтын ажил гүйлгээг хийсэн байна.

<i>Төгрөгөөр</i>	2025	2024
<u>Борлуулалт:</u>		
Хувьцаа эзэмшигч	750,453,146	372,775,431
<u>Борлуулалтаас төлсөн:</u>		
Хувьцаа эзэмшигчээс	309,112,821	278,315,575

30. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл (үргэлжлэл)

Холбоотой талуудтай худалдан авалтын ажил гүйлгээг хийсэн байна.

<u>Төгрөгөөр</u>	2025	2024
<u>Худалдан авалт:</u>		
Хувьцаа эзэмшигч	493,093,000	-
Хараат компани	28,600,000	
<u>Худалдан авалтаас төлсөн:</u>		
Хувьцаа эзэмшигчээс	595,390,225	-
Хараат компани	28,600,000	

31. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдэлийн удирдлага

Компанийн үйл ажиллагаанд эрсдэл учрах асуудлууд байдаг бөгөөд эдгээр эрсдэлд эзэлийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, хүүгийн эрсдэл багтах ба уг эрсдэлүүдийг Компанийн Гүйцэтгэх захирал удирдан зохицуулна. Эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь эрсдэлийг тогтмол тодорхойлж, хэмжиж, хянах ба ингэснээр эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хэмжээнд барих явдал юм. Эрсдэлийн удирдлагын дээрх процесс нь компанийн тогтвортой хөгжилд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд компанийн ажилтан бүр өөр өөрсдийн ажил үүргийн хүрээн дэх эрсдэлд хариуцлагатай хандах ёстой.

Компанийн санхүүгийн үндсэн хэрэгслүүд нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, дансны ба бусад авлага, зээл, дансны ба бусад өглөг, нөөцөөс бүрддэг.

Компанийн санхүүгийн үндсэн хэрэгслүүдэд тодорхойлсон эрсдэлүүд нь аудит хийх явцад тодорхойлсон болзошгүй эрсдэлүүд ба урьдчилан тодорхойлох боломжгүй, гэнэтийн болон эрсдэл гэж тооцоогүй үйл явдлууд нь компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлт, ирээдүйн ашигт сөргөөр нөлөөлж болно.

Санхүүгийн хэрэгслийн ангилал:

<u>Төгрөгөөр</u>	2025	2024
Санхүүгийн хөрөнгө:		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	682,285,678	774,338,031
Зээл ба авлага	6,281,900,067	5,801,219,552
Санхүүгийн өр төлбөр:		
Худалдааны болон бусад өр төлбөр	396,237,997	454,106,543

Компани нь үйл ажиллагаагаа санхүүжүүлэхийн тулд эдгээр санхүүгийн хэрэгслүүдийг эзэмшдэг. Компани арилжаалах болон санхүүгийн хамгаалалт хийх зорилгоор санхүүгийн хэрэгслүүдийг эзэмшдэггүй.

32. Капиталын эрсдлийн удирдлага

Компани тасралтгүй үйл ажиллагаа явуулах зорилгоор өөрийн капиталыг удирдахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчийн өгөөжийг хамгийн ихээр байлгахын тулд зээл болон өөрийн хөрөнгийн харьцааг оновчтой байлгахыг зорьдог. Компанийн капиталын бүтэц нь цэвэр зээл (зээлээс мөнгөн хөрөнгийг хассан) ба өөрийн хөрөнгөөс бүрдэх бөгөөд өөрийн хөрөнгө нь дүрмийн сан болон хуримтлагдсан ашгаас тус тус бүрддэг.

33. Гэрээний үүрэг

Компанид 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар томоохон капитал худалдан авалтын үүрэг байхгүй.

34. Тайлангийн дараах үйл явдал

Компанийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөхүйц, тодруулахыг шаарддаг тайлангийн дараах үйл явдал гараагүй.

35. Орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Монгол хэл дээр хувилбарыг баримтална.

36. Хураангуй товчлол

Товчлол	Товчилсон үгсийн тайлбар
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БҮЦАА	Бодит үнэ цэнийн ашиг, алдагдал
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТК	Нэмж төлөгдсөн капитал
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл